

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/20/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: [khuanganm@audit.gov.mn](mailto:khuanganm@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)  
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)  
Аудитор: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ч.ГЭРЭЛТУЯА ТАНАА

2023.02.17 № 98  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын ерөнхий 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Хүнсний материалын бүртгэл, тооллого, хяналт тавих асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,619,546.45	84,766,160.83
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	(0.00)	42,326,119.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	(0.00)	42,326,119.38
3121	Төгрөг	(0.00)	42,326,119.38
31211	Төрийн сангийн харилцах	(0.00)	42,326,119.38
35	БАРАА МАТЕРИАЛ	28,619,546.45	42,440,041.45
	Түүхий эд материал	5,082,000.00	5,005,000.00
35110	Тусгай зориулалттай материал	4,945,000.00	4,945,000.00
35130	Эм боох материал	137,000.00	60,000.00
354	Хангамжийн материал	23,537,546.45	37,435,041.45
35410	Бичиг хэргийн материал	720,000.00	912,500.00
35420	Аж ахуйн материал	10,123,450.00	12,054,110.00
35440	Түлш шатах тослох материал	1,396,600.00	1,917,600.00
35460	Хүнсний материал	6,944,186.45	15,325,096.45
35470	Бусад хангамжийн материал	4,353,310.00	7,225,735.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	618,927,478.38	664,208,141.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	618,927,478.38	664,208,141.77
392	Биет хөрөнгө	611,473,478.38	656,754,141.77
39201	Барилга, байгууламж	582,584,446.62	653,584,446.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,133,059.30)	(90,127,918.38)
39205	Машин, тоног төхөөрөмж	80,501,952.00	90,440,852.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,729,620.64)	(29,549,397.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,047,809.00	36,047,809.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,669,718.30)	(11,823,819.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	300,000.00	300,000.00
39217	Номын фонд	7,571,669.00	7,882,169.00
393	Биет бус хөрөнгө	7,454,000.00	7,454,000.00
39301	Програм хангамж	383,500.00	383,500.00
39302	Хасагдуулга	(383,500.00)	(383,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,454,000.00	7,454,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	647,547,024.83	748,974,302.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	647,547,024.83	748,974,302.60
51	Засгийн газрын хувь оролцоо	647,547,024.83	748,974,302.60
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	51,413,284.00	51,413,284.00
51101	Өмч: -Төрийн өмч	51,413,284.00	51,413,284.00
512	Хуримтлагдсан үр дүн	511,569,657.21	612,996,934.98
51210	Өмнөх үеийн үр дүн	511,569,657.21	511,569,657.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	101,427,277.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,564,083.62	84,564,083.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	647,547,024.83	748,974,302.60

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Алтай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	241,867,425.00	401,729,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,383,210.00	6,244,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,383,210.00	6,244,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,383,210.00	6,244,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,383,210.00	6,244,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	34,096,115.00	395,485,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,275,100.00	360,198,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	282,129,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	8,275,100.00	78,069,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	203,388,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,136,015.00	3,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	2,136,015.00	3,750,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,294,000.00	28,536,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,294,000.00	28,536,500.00
132005	Хөрөнгийн санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8,000,000.00	3,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	11,391,000.00	3,000,000.00
133003	Хөрөнгийн	3,391,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	250,294,831.63	300,301,922.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,294,831.63	300,301,922.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,315,626.63	292,388,831.23
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	152,546,326.00	186,106,565.00
210101	Цалин	141,690,336.00	149,271,633.00
210102	Нэмэгдэл цалин	-	28,522,392.00
210104	Урамшуулал	6,318,190.00	8,312,540.00
210105	Гэрээтийн цалин	4,537,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,493,074.00	23,051,504.62
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,417,974.00	16,075,184.17
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,506,900.00	1,738,255.65
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,205,600.00	1,390,104.99
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	301,400.00	337,420.02
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,061,200.00	3,510,539.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,611,746.00	12,863,200.00
210301	Гэрэл цахилгааны зардал	218,300.00	122,000.00
210302	Түлш, халаалтын зардал	16,181,946.00	12,741,200.00
210303	Цэвэр, бохир усны зардал	211,500.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	6,846,120.00	106,075.00
210401	Бичиг хэргийн материал	299,800.00	-
210402	Тээвэр, шатахууны зардал	3,280,980.00	-
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	657,500.00	-
210404	Ном, хэвлэлийн зардал	40,000.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,567,840.00	106,075.00
2105	Нормативт зардал	21,201,525.00	19,729,960.00
210501	Эм	239,000.00	162,000.00
210502	Хоол	20,857,025.00	19,567,960.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	105,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,200.00	-
210604	Урсгал засвар	167,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	78,300.00	-
210702	Дотоод томилолтын зардал	78,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	358,200.00	4,557,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,700.00	3,344,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	345,500.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	1,213,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,013,135.63	45,974,526.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,290,890.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,206,575.00	3,714,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,806,560.63	35,968,736.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	979,205.00	7,913,091.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	979,205.00	7,375,230.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	979,205.00	7,375,230.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	537,861.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	537,861.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(8,427,406.63)	101,427,277.77
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	971,200.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	971,200.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(971,200.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(9,398,606.63)	101,427,277.77

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	217,818,115.00	314,415,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	217,818,115.00	314,415,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	282,129,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	282,129,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	203,388,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,136,015.00	3,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	2,136,015.00	3,750,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,294,000.00	28,536,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,294,000.00	28,536,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	217,738,115.00	271,909,680.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,738,115.00	271,909,680.62
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	211,910,615.00	262,513,319.62
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	150,695,500.00	186,106,565.00
210101	Үндсэн цалин	137,672,900.00	142,114,544.00
210102	Нэмэгдэл	-	34,900,771.00
210104	Үр дүнгийн урамшуулал	8,484,800.00	9,091,250.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	-
2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,343,900.00	23,051,504.62
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,316,100.00	16,075,184.17

Алтай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,506,900.00	1,738,255.95
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,205,600.00	1,390,104.99
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	301,400.00	337,420.02
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,013,900.00	3,510,539.49
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	11,794,000.00	14,484,000.00
210301	Гэрэл цахилгааны зардал	864,000.00	1,364,000.00
210302	Түлш, халаалтын зардал	9,430,000.00	12,466,800.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,500,000.00	653,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,985,800.00	-
210401	Бичиг хэрэг	66,800.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,913,800.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	657,500.00	-
210404	Ном, хэвлэл	19,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	328,100.00	-
2105	Нормативт зардал	21,177,500.00	26,465,600.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	220,400.00	-
210502	Хоол, хүнс	20,443,100.00	26,465,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	514,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	550,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	550,000.00
2107	Томилолт, зочны зардал	78,300.00	-
210702	Дотоод албан томилолт	78,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,900.00	1,467,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	97,900.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,467,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,837,715.00	10,388,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,993,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	2,837,715.00	2,394,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,827,500.00	9,396,361.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,827,500.00	8,858,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	5,827,500.00	8,858,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	537,861.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	537,861.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	80,000.00	42,506,119.38
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	80,000.00	180,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,000.00	180,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	80,000.00	180,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,000.00	180,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(80,000.00)	(180,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	42,326,119.38
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	(0.00)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(0.00)	42,326,119.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Ү	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
1	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	43,959,284.00	16,107,743.00	(2,671,073.82)	57,395,953.18
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,959,284.00	16,107,743.00	(2,671,073.82)	57,395,953.18
3	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	4,628,428.40	4,628,428.40
4	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	51,413,284.00	84,564,083.62	511,569,657.21	647,547,024.83
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	51,413,284.00	84,564,083.62	511,569,657.21	647,547,024.83
7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	101,427,277.77	101,427,277.77
8	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	51,413,284.00	84,564,083.62	612,996,934.98	748,974,302.60

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Төгрөгөөр

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	309,465,800.00	266,601,819.62	42,863,980.38	86.15%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	309,465,800.00	266,601,819.62	42,863,980.38	86.15%
210	Бараа, үйлчилгээний зардал	300,607,300.00	257,743,319.62	42,863,980.38	85.74%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,278,900.00	181,906,565.00	31,372,335.00	85.29%
210101	Үндсэн цалин	166,125,400.00	140,914,544.00	25,210,856.00	84.82%
210102	Нэмэгдэл	43,077,400.00	34,900,771.00	8,176,629.00	81.02%
210104	Урамшуулал	4,076,100.00	6,091,250.00	(2,015,150.00)	149.44%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,319,700.00	23,051,504.62	3,268,195.38	87.58%
210201	Тэтгэврийн даатгал	17,913,400.00	16,075,184.17	1,838,215.83	89.74%
210202	Тэтгэмжийн даатгал	2,108,300.00	1,738,255.95	370,044.05	82.45%
210203	ҮОМШӨ ний даатгал	1,686,100.00	1,390,104.99	295,995.01	82.44%
210204	Ажилгүйдлийн даатгал	419,300.00	337,420.02	81,879.98	80.47%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,192,600.00	3,510,539.49	682,060.51	83.73%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,664,000.00	14,664,000.00	-	100.00%
210301	Гэрэл цахилгаан	1,364,000.00	1,364,000.00	-	100.00%
210302	Түлш, халаалт	12,300,000.00	12,300,000.00	-	100.00%
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	-	100.00%
2105	Нормативт зардал	26,465,600.00	26,465,600.00	-	100.00%
210502	Хоол, хүнс	26,465,600.00	26,465,600.00	-	100.00%
2106	Эд хогшил худалдан авах	550,000.00	550,000.00	-	100.00%
210604	Урсгал засвар	550,000.00	550,000.00	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,511,800.00	1,467,550.00	44,250.00	97.07%
210806	Мэдээллийн технологийн зардал	1,511,800.00	1,467,550.00	44,250.00	97.07%
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	17,817,300.00	9,638,100.00	8,179,200.00	54.09%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,422,600.00	7,243,400.00	8,179,200.00	46.97%

Алтай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	2,394,700.00	-	100.00%
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,858,500.00	8,858,500.00	-	100.00%
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,858,500.00	8,858,500.00	-	100.00%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	8,858,500.00	8,858,500.00	-	100.00%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	309,465,800.00	281,467,161.00	27,998,639.00	90.95%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	280,929,300.00	280,929,300.00	-	100.00%
131001	Улсын төсвөөс санхүүжих	280,929,300.00	280,929,300.00	-	100.00%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,536,500.00	27,998,639.00	537,861.00	98.12%
132001	Орон нутгийн төсвөөс	28,536,500.00	27,998,639.00	537,861.00	98.12%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	42,326,119.38	(42,326,119.38)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	51.00	51.00	-	100.00
630	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	51.00	51.00	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	51.00	51.00	-	100.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв 3 750,0 мянган төгрөг авсан байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог ханган, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж үр дүнтэй хэрэгжүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг ахиулах
- Даалгаварт суурилсан арга зүйг боловсруулж, сургалтын чанарт ахиц гаргах.

- Багш,ажилчид,сурагчдыг стресээс сэргийлэх,айдас түгшүүр, сэтгэл зовнилгүй ажиллах,суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжин оролцоог хангаж, сургууль завсардахаас сэргийлэн, эцэг эх олон нийттэй хамтран ажиллах.
- Монгол хэл бичгийн чадварыг сайжруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх.
- "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3"-ын хүрээнд сургуулийн мэргэжлийн бүлгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.
- Сурагчдыг тэгш хамааруулан сургах үйлийг дэмжих дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн захирлын 2019 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн А-45 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101.7 сая төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	-	42.326.1	42.326.1
Авлага	-	-	-
Бараа материал	28.619.5	42.440.0	13.820.5
Үндсэн хөрөнгө	618.927.5	664.208.1	45.280.7
Нийт хөрөнгө	<b>647.547.0</b>	<b>748.974.3</b>	<b>101.427.3</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	647.547.0	748.974.3	101.427.3
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	<b>647.547.0</b>	<b>748.974.3</b>	<b>101.427.3</b>

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 42.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс цалингийн зардал, хоол хүнс, бараа үйлчилгээний бусад зардлуудын хэмнэлт байна. Цалингийн хэмнэлт 31.4 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 74.2% хувийг, ажил олгогчын шимтгэл 3.3 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 7.8 хувийг, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт 7.6 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 18.0 хувийг тус тус эзэлж байна.

Авлагын дансны өөрчлөлтгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс 45.2 сая төгрөгөөр өссөн нь 81.2 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 36.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

БӨА-2023/20/НА-СТА-ТШЗ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 345.3 сая, орон нутгийн төсвөөс 62.0 сая, нийт зарлагыг 407.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 92.9 сая төгрөгөөр бууруулж 309.5 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 313.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 28.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 238,6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 266,6 сая төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 23.2 сая төгрөгөөр, нэмэгдэл цалингийн төсвийг 8.2 сая төгрөгөөр, ажил олгогчийн шимтгэлийн зардлын төсвийг 3,3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 7.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	1.747.8	1.703.5	44.3	97.47%
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	8.022.7	8.022.7	-	100.00%
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	684.2		684.2	0.00%
4	Дотуур байрны үйлчилгээ	41.430.7	37.520.3	3.910.4	90.56%
5	Боловсролын стандарт сургалт	176.343.4	158.086.6	18.256.8	89.65%
6	Үдийн цай хөтөлбөр	8.858.5	8.858.5	-	100.00%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7.495.0		7.495.0	0.00%
8	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1.379.4	1.379.4	-	100.00%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	34.967.6	23.032.1	11.935.5	65.87%
10	Нийтлэг үйлчилгээ	28.536.5	27.998.6	537.9	98.12%
	<b>Дүн</b>	<b>309.465.8</b>	<b>266.601.8</b>	<b>42.864.0</b>	<b>86.15%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд 3,7 сая төгрөгийн нэмэлт төсөв авсан байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 250.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Алтай сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 733.3 мянган төгрөгийн 1 акт өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	733,300.00	1	733,300.00	100%
Албан шаардлага					
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>733,300.00</b>	<b>1</b>	<b>733,300.00</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалын тооллоготой холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Хүнсний материалын үлдэгдэлд байгаа 15.3 сая төгрөгийн материалд өмнөх онуудын хүнсний материалын үлдэгдлээс 0,4 сая төгрөгийн хүнсний материалыг зарлагын гүйлгээ гараагүй байгаа нь хүнсний материалын үлдэгдлийн тооллогыг зохих журмаар хийж баталгаажуулаагүй, хүнсний материалын тооллогыг бодитой хийсэн эсэх, үлдэгдэл бодитой байгаа эсэх нь тодорхой бус байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж хүнсний материалыг хэрэгцээнд тулгуурлан худалдан авалт хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасныг дагуу хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллогыг бодитой хийж үлдэгдлийг баталгаажуулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бараа материалын тооллого хийгээгүй,	1	15.315.6										1	15.315.6

